



ӨМНӨХ ҮГ

Монгол улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, Шинжлэх ухааны академи байгуулагдсаны 60 жил, Хими, химийн технологийн хүрээлэнгийн 60 жилийн тэгш ой давхацсан энэ түүхэн жилд тус хүрээлэнгээс жил бүр эрхлэн гаргадаг “Эрдэм шинжилгээний бүтээл” (Bulletin of Institute of Chemistry and Chemical Technology, BICCT) сэтгүүлийн дугаар 9 буюу 2021 оны дугаар хэвлэгдэн гарч байна. Манай сэтгүүлд өөрсдийн судалгааны ажлын шинэ үр дүн, шинэлэг санаагаа нэгтгэн өгүүллээ ирүүлсэн эрхэм эрдэмтэн судлаачид та бүхэндээ талархал илэрхийлье.

Эрдэм шинжилгээний бүтээл сэтгүүл нь Google Scholar, Dimensions, CNKI Scholar зэрэг хайлтын төрөлжсөн системүүдэд бүртгэгдэн, хэвлэгдсэн өгүүллүүд нь DOI дугаартай гардаг бөгөөд бид хайлтын системийн бүртгэлийг цаашид өргөжүүлэх, олон улсын мэргэжлийн сэтгүүлийн стандарт шаардлагыг хангахаар хичээнгүйлэн ажиллаж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт органик хими, органик бус хими, нүүрсний химийн технологи, экологийн хими, байгалийн нэгдлийн химийн нийт 5 салбарын 6 өгүүлэл сэтгүүлийн шаардлагыг ханган хэвлэгдэж байна. Хэвлэгдсэн бүтээлүүдийн заримаас товч дурьдвал:

Г.Ариунаа нарын судлаачид “*Асгатын полиметаллын баяжмал дахь хортой элементүүдийг уусгах аргаар ялгаж авах судалгааны зарим үр дүн*”-ээр Асгат ордын полисульфидийн баяжмалын хими, эрдсийн найрлагыг тодорхойлж, түүнд агуулагдах хортой бүрдэл элемент болох сурьмаг уусган авах тохиромжтой горимыг тогтоожээ. Түүнчлэн судлаач А.Алтангэрэл нар усан уусмал дахь хүнцэл (As(V))-ийг электрокоагуляцийн аргаар тунадасжуулах зохистой нөхцлийг тогтоож, As(V)-ийн зайлуулалт нь химийн тунадасжилт, адсорбцийн процессоор явагддагийг илрүүлэв.

Экологийн химийн чиглэлээр Улаанбаатар хот орчмын Туул голын урсгалын дагуух 10 цэгийн усны физик-химийн болон бохирдлын үзүүлэлтийг тодорхойлон, усны чанарын судалгааг явуулсны үндсэн дээр бохирдлын түвшинг тогтоон үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Б.Ганцэцэг нарын судлаачид Цагаан-Элсний ордын нефтийн хатуу парафиныг исэлдүүлэн гадаргуугийн идэвхт үйлчлэлтэй угаагч бодисын гол түүхий эд болох нийлэг тосны хүчил гарган авах боломжтойг тогтоосон бол Нүүрсний хими технологийн чиглэлээр Тавантолгойн ордын овоолгын исэлдсэн нүүрс болон эрчим хүчний чулуун нүүрсний хийжүүлэлтийн идэвхэд эх эрдсүүдийн нөлөө, мөн төмөр (Fe), натри (Na) болон хосолсон Fe+Na катализаторуудын үзүүлэх нөлөөг тодорхойлсон байна.

Манай сэтгүүлтэй нэгэн сэтгэлээр хамтран ажиллаж буй хөндлөнгийн шүүмжлэгч нартаа талархал илэрхийлэхийн ялдамд эрхэм эрдэмтэн судлаач та бүхнийг эрдэм шинжилгээний шинэхэн өгүүллүүдээ ирүүлэхийг урьж байна.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР ЛХАСҮРЭНГИЙН ЖАРГАЛСАЙХАН